

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын Спорт Цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/87/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Ахлах аудитор: Л.Галбадрах Утас: 70432545 цахим хаяг: galbadrah.L@audit.gov.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал .....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
4. Аудитын илрүүлэлт .....	11
4.1 Залруулсан алдаа .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	11

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

МАНХАН СУМЫН СПОРТ  
ЦОГЦОЛБОРЫН ДАРГА А.ДАШНЯМ  
ТАНАА

2022.02.24 № 2/87  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын спорт Цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манхан сумын Спорт Цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>12455700.0</u></b>	<b><u>15414879.5</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	12455700.0	15414879.5
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12455700.0	15414879.5
35410	Бичиг хэргийн материал	150000.0	150000.0
35420	Аж ахуйн материал	3762800.0	6721979.5
35470	Бусад хангамжийн материал	8542900.0	8542900.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2350592715.9</u></b>	<b><u>2300472605.4</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2350592715.9	2300472605.4
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2350592715.9	2300472605.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	2485724550.0	2485724550.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-163866667.0	-206219561.2
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21634600.0	21634600.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11567967.0	-16128583.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19786000.0	19786000.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5792800.1	-7899400.1
39214	Бусад үндсэн хөрөнгө	5500000.0	5500000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-825000.0	-1925000.1
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2363048415.9</u></b>	<b><u>2315887484.9</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>677395.4</u></b>	<b><u>89110.9</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	677395.4	89110.9
<b>413</b>	<b>Өглөг</b>	677395.4	89110.9
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	677395.4	89110.9
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2362371020.5</u></b>	<b><u>2315798374.1</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2362371020.5	2315798374.1
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2362371020.5	2315798374.1
51210	Өмнөх үеийн үр дүн	2362371020.5	2362371020.5
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	-46572646.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2363048415.9</u></b>	<b><u>2315887484.9</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>163763550.0</u></b>	<b><u>140207300.0</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>32724550.0</u></b>	<b><u>3484000.0</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32724550.0	3484000.0

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32724550.0	3484000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5000000.0	3484000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27724550.0	0.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>131039000.0</b>	<b>136723300.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	131039000.0	0.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	131039000.0	0.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	0.0	136723300.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.0	136723300.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>186398890.9</b>	<b>186779946.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>186398890.9</b>	<b>186779946.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	186398890.9	186779946.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	63961340.0	65246178.0
210101	Үндсэн цалин	63164187.0	65246178.0
210102	Нэмэгдэл	797153.0	0.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7995167.5	8577847.9
210201	Тэтгэврийн даатгал	5436713.9	6143658.3
210202	Тэтгэмжийн даатгал	639613.4	588030.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	511690.7	472386.1
210204	Ажилгүйдлийн даатгал	127922.7	118298.5
210205	Эрүүл мэндийн даатгал	1279226.8	1255474.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61419579.7	58651320.5
210301	Гэрэл, цахилгаан	2388579.7	1436320.5
210302	Түлш, халаалт	56546000.0	55290000.0
210303	Цэвэр, бохир ус	2485000.0	1925000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2503700.0	1914839.6
210401	Бичиг хэрэг	325000.0	232500.0
210402	Тээвэр, шатахуун	600000.0	368139.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75000.0	160000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1433700.0	1154200.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	70000.0	0.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	632300.0	0.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24500.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	607800.0	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.0	408300.0
210604	Урсгал засвар	0.0	408300.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.0	64000.0
210702	Дотоод албан томилолт	0.0	64000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	537000.0	1655350.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	447000.0	1565350.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90000.0	90000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	49349803.7	50262110.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	905920.3	142000.0

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48443883.4	50120110.4
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-22635340.9</b>	<b>-46572646.5</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	0.0	0.0
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-22635340.9</b>	<b>-46572646.5</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,385,534,161.4	2,385,534,161.4
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>2,385,534,161.4</b>	2,385,534,161.4
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(23,163,140.9)	(23,163,140.9)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	<b>2,362,371,020.5</b>	2,362,371,020.5
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	<b>2,362,371,020.5</b>	2,362,371,020.5
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	<b>2,362,371,020.5</b>	2,362,371,020.5
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(46,572,646.5)	(46,572,646.5)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	<b>2,315,798,374.1</b>	2,315,798,374.1

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>136039000.0</b>	<b>140207300.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5000000.0</b>	<b>3484000.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5000000.0	3484000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5000000.0	3484000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5000000.0	3484000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>131039000.0</b>	<b>136723300.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	131039000.0	0.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	131039000.0	0.0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	0.0	136723300.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.0	136723300.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>136039000.0</b>	<b>140207300.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>136039000.0</b>	<b>140207300.0</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>135511200.0</b>	<b>140207300.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	62777800.0	65505510.4
210101	Үндсэн цалин	57001267.0	61158719.0
210102	Нэмэгдэл	5776533.0	4346791.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8475000.0	8906800.0
210201	Тэтгэврийн даатгал	5963800.0	6267700.0
210202	Тэтгэмжийн даатгал	627800.0	659800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	502200.0	527800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	125600.0	132000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1255600.0	1319500.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62732200.0	61700000.0
210301	Гэрэл, цахилгаан	3300000.0	4100000.0
210302	Түлш, халаалт	56546000.0	55290000.0
210303	Цэвэр, бохир ус	2886200.0	2310000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1084200.0	646639.6
210401	Бичиг хэрэг	230000.0	118500.0
210402	Тээвэр, шатахуун	600000.0	368139.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75000.0	160000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	179200.0	0.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	120000.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120000.0	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.0	1000000.0
210604	Урсгал засвар	0.0	1000000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.0	64000.0
210702	Дотоод албан томилолт	0.0	64000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	322000.0	2384350.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232000.0	2294350.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90000.0	90000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>527800.0</b>	<b>0.0</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	527800.0	0.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	527800.0	0.0
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.0	0.0
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.0	0.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	141723300.0	140207300.0
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	141723300.0	140207300.0
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	141723300.0	140207300.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	65975800.0	65505510.4
210101	Үндсэн цалин	61303600.0	61158719.0
210102	Нэмэгдэл	4672200.0	4346791.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8906800.0	8906800.0
210201	Тэтгэврийн даатгал	6267700.0	6267700.0
210202	Тэтгэмжийн даатгал	659800.0	659800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	527800.0	527800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	132000.0	132000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1319500.0	1319500.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61700000.0	61700000.0
210301	Гэрэл, цахилгаан	4100000.0	4100000.0
210302	Түлш, халаалт	55290000.0	55290000.0
210303	Цэвэр, бохир ус	2310000.0	2310000.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1190000.0	646639.6
210401	Бичиг хэрэг	230000.0	118500.0
210402	Тээвэр, шатахуун	600000.0	368139.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160000.0	160000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200000.0	0.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	150000.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150000.0	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1000000.0	1000000.0
210604	Урсгал засвар	1000000.0	1000000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	320000.0	64000.0
210702	Дотоод албан томилолт	320000.0	64000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2480700.0	2384350.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2390700.0	2294350.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90000.0	90000.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	140723300.0	140207300.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	135723300.0	0.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	135723300.0	0.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	0.0	136723300.0
132001	Орон нутгийн төсвөөс	0.0	136723300.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	5000000.0	3484000.0

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5000000.0	3484000.0
---------	--	-----------	-----------

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Манхан сумын Спорт цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Л.Галбадрах 2022 оны 02 дүгээр сарын 18-нээс 2022 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ний өдрийн 1 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Манхан сумын Спорт Цогцолбор нь “ Хүүхэд, залуучуудыг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, эрүүл чийрэг бие бялдар, өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, олимп, тив, дэлхийн спортын уралдаан, тэмцээнд амжилттай оролцох баг, тамирчдыг бэлтгэх спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангахад, оршино.” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх тухай түүнд нийцүүлэн гаргасан хуулийг баримталж, орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг хангах, мэдээллийг үнэн бодитой, шуурхай мэдээлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй, ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Манхан сумын Спорт Цогцолбор 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 186.7 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 3.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Манхан сумын Спорт Цогцолбор 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46.5 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15.4 сая төгрөг болж 2.9 сая төгрөгөөр буюу хангамжийн материалын үлдэгдлээр өссөн байна. Тайлант хугацаанд бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 3.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 15.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд болон оны эцэст 2532.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст 0.8 мянган төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь нийгмийн даатгалын шимтгэлийн холбоотой үүссэн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2362.3 сая төгрөг байсан оны эцэст 2315.7 сая төгрөг болж тайлант онд 46.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 46.7 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Манхан сумын спорт цогцолбор нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 136.7 сая төгрөг, түрээсийн орлого 3.4 төгрөгөөр, нийт зарлагыг 140.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 136.7 сая төгрөг батлан, түрээсийн орлого 3.4 сая төгрөгөөр төвлөн ирүүлжээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 136.7 сая төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, түрээсийн орлого 3.4 сая төгрөг, нийт 140.2 сая төгрөгөөр төлөвлөжээ.

Өөрийн орлогын төлөвлөгөө 5.0 сая бүрдүүлэх ёстойгоос 3.4 сая төгрөгийг бүрдүүлж ковид цар тахлын улмаас өөрийн орлогын төлөвлөөг бүрдүүлж чадаагүй, төсвийн 46.7 хувийг цалингийн зардал эзэлж байгаа зэрэг нөхцөлүүдийг хянахад Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн хэмнэлт гаргах боломжгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт дансгүй болно.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 150 мэдээллийг хугацаандаа оруулсан байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн “6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор” гэсэн заалтыг хэрэгжүүлэн хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансны сайтад байршуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд и баримт бүрдүүлэлтийг сайжруулах, шилэн дансны мэдээллийг хугацаандаа оруулж байх зөвлөмж өгсөн байна.. Өгсөн зөвлөмжийг тайланд онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн алдаа зөрчил байхгүй болно.

### 4.1 Залруулсан алдаа

- Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Манхан сумын спорт цогцолбор	0	0					0	0	0	0

### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

### ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Л.Галбадрах